

АВСТРИЙН ТЭТГЭЛГИЙГ 23 ДОКТОРАНТ АВЛАА



Энэ тухай СЗ нүүрээс уншина уу



Хоёр нарны хооронд

ХЭДХЭН ҮГЭЭР

- ♦ "Монголд хөрөнгө оруулах боломжууд, хөрөнгө оруулалтын төслийг танилцуулах нь" сэдэвт бизнес уулзалт ирэх сарын 6-10-нд болно. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг, Солонгосын гадаад худалдааг дэмжих агентлагтай хамтран зохион байгуулах уулзалт Сөүл хотод болох юм.
- ♦ Нийслэлийн 367 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатарын бизнес эрхлэгчдийн анхдугаар зөвлөлгөөн "Hi tech Улаанбаатар-2006" үзэсгэлэн 2006 оны аравдугаар сарын 23-24-нд болно.

- ♦ Зэвсэгт хүчний байгууллагыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр баталгаажуулжээ.

ӨЧИГДӨР

- ♦ Батлан хамгаалах их сургуулийн 85 жилийн ойд зориулсан баярын хурал, концерт боллоо.
- ♦ "Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны төлөв" сэдэвт Ази, Номхон далайн орнуудын VII бага хурал өндөрлөв. Азийн олон орноос төлөөлөгч оролцсон хурал хоёр өдөр үргэлжилнэ.
- ♦ Замын цагдаагийн газрын Хэрэг бүртгэх хэлтсийн даргын суудал эзэнтэй болов. Энэ албан тушаалд Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн Хэрэг бүртгэх тасгийн дарга Б.Эрдэнэбаатар томилогджээ.

ӨНӨӨДӨР

- ♦ Япон хэлний багш болон энэ мэргэжлээр ажиллах сонирхолтой оюутнуудад зориулан "Япон хэл заах аргачлал" сэдэвт сургалт болно. 18-20 цагийн хооронд болох уг сургалт үнэ төлбөргүй ажээ.

- ♦ Замын цагдаагийн газрын ажилтнуудад зориулсан "Цагдаа ба хүний эрх" сэдэвт сургалт өндөрлөнө. Хүний эрхийн тухай, цагдаагийн албан хаагчидтай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт, тэдний харилцааны соёл, түүний үр дагавар зэрэг өргөн хүрээг хамарч буй уг сургалт хоёр хоног үргэлжилж байгаа юм.

МН- МЭДЭЭЛЛИЙН ТӨВД

Утас: 9979803

11.00 цагт Ард түмний нам дэмжигч залуучуудаа сэтгүүлчдэд мэдээлэл хийнэ.
12.00 цагт MCS группээ сайн үйлсийн аяныг зохион байгуулж байгаа тухай мэдээлэхээр сэтгүүлчдийг урьж байна.
13.00 цагт Сонирхогчдыг сүмогийн ДАШТ-д мангатамирчид амжилттай оролцожээ. Энэ тухай Сүмогийн холбооноос мэдээлнэ.



УЛААНБААТАР

үүлэрхэ

0°C + 2°C

салхи 4-9 м/с